



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

“Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд нийт 39,231,166.27 (гучин есөн сая хоёр зуун гучин нэгэн мянга нэг зуун жаран зургаан төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөл (Ж.Ганбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ хавсралтын дагуу бүртгэн авч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Замын хөдөлгөөн удирдлагын төв” ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн өмчийн харилцааны газрын
2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
А.Б. дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Хөгжлийн хөтөч дэд бүтэц" төсөл

№	Эд хогшлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллага
1	Гэрлэн дохио (Баянзүрх дүүрэг, Доржийн гудамж Монелийн уулзвар)	ш	5	2022	7,846,233.25	39,231,166.25	7,846,233.25	31,384,933.00	"Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төсөл	"Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ
Бусад үндсэн хөрөнгө					7,846,233.25	39,231,166.25		31,384,933.00		
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн					7,846,233.25	39,231,166.25		31,384,933.00		